



МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

2021 оны 3 дугаар сар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	2
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	8
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	9
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	9
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	12
2.3. Төсвийн тэнцэл:	13
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	14
3.1. Гадаад худалдааны эргэлт:	14
3.2. Экспорт:	15
3.3. Импорт:	16
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	18
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	18
4.2. Гадаад валютын албан нөөц:	20
4.3. Төлбөрийн тэнцэл:	21
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	22
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	22
5.2. Ажилгүйдэл:	23



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

КОВИД-19 вирусын тархалт үргэлжилж, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр 2020 онд эдийн засгийн өсөлт огцом саарч макро түвшний голлох үзүүлэлтүүд буурч эдийн засаг агшихад нөлөөллөө.



Эдийн засгийн өсөлт огцом буурлаа. ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтээ хүрсэн. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны эхний улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьд хүрсэн нь 2016 оноос хойш хамгийн их агшсан үзүүлэлт болов. Харин 2020 оны эхний хагас жилд -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрч эдийн засаг эргэн сэргэх хандлага ажиглагдаж байна.

Нэгдсэн төсвийн тэнцэл алдагдалтай гарсан байна. 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 12.3 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарлаа. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,782.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол төлөвлөсөн дүнгээс 509.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,421.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 13.6 хувь буюу 1,483.9 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 6.3 хувь буюу 636.4 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 15,106.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 92.4 хувийг ашиглаж 1,145.4 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,299.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч өмнөх оны мөн үеэс өсжээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харицуулахад 790.3 сая ам.доллараар өсөж 2,282.4 сая ам.долларын ашигтай гарчээ. Тэнцэл 53.0 хувиар өсөхөд импортын бууралт 833.5 сая ам.доллар болж экспортын бууралтаас 19.2 дахин их байгаа нь нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 24,220.0 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3,386.4 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс буурлаа. Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны жилийн эцэст 2.3 хувь болж өмнөх сараас 1.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан байна.

Гадаад валютын нөөц нэмэгдлээ. Гадаад валютын нөөцийн хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 4,534.2 сая ам.долларт хүрээд байна. Нөөцийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 185.6 сая ам.доллар буюу 4.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 576.2 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 1,494.3 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 786.9 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 334.0 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаа буурчээ. Үнэт цаасны арилжаагаар 2020 оны жилийн эцэст нийт 353.3 сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, 53.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 66.6 хувиар буурсан байна.

Төгрөгийн ханш суларсан байна. 2020 оны жилийн эцэст Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,849.55 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.02 хувиар чангарсан бол оны эхнээс 3.8 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 435.64 төгрөг болж өмнөх сараас 1.0 хувиар, оны эхнээс 9.9 хувиар суларсан байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцэст 1,269.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 445.3 тэрбум төгрөг буюу 54.0 хувиар өссөн байна. Түүнчлэн банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны жилийн эцэст 2,009.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 184.4 тэрбум төгрөг буюу 10.1 хувиар өссөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ


1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 37.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 их наяд төгрөг буюу 0.2 хувиар буурсан байна.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн 2016 онд 23.9 их наяд, 2017 онд 27.9 их наяд, 2018 онд 32.4 их наяд, 2019 онд 37.4 их наяд төгрөгт хүрч тасралтгүй өсөлттэй байсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 0.1 их наяд төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

График 1. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн хэрэглээ өмнөх оноос 1.7 их наяд төгрөгөөр буюу 7.0 хувиар, цэвэр экспорт 3.9 их наяд төгрөгөөр буюу 172.5 хувиар өссөн ч **хөрөнгийн хуримтлал 5.7 их наяд төгрөг буюу 38.4 хувиар буурсан** нь ДНБ-ий дүн буурахад нөлөөлсөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар: 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 18.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 1.1 их наяд төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

График 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Зэрэгцүүлэх үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2016 онд 16.2 их наяд, 2017 онд 17.0 их наяд, 2018 онд 18.2 их наяд, 2019 онд 19.2 их наяд төгрөгт хүрч байсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18.1 их наяд төгрөг болж, 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

Эцсийн хэрэглээ 0.7 их наяд төгрөг буюу 5.1 хувиар, цэвэр экспорт 1.9 их наяд төгрөгөөр буюу 48.1 хувиар өссөн боловч **хөрөнгийн хуримтлал 3.7 их наяд төгрөг буюу 42.5 хувиар буурсан** нь ДНБ¹-ий дүн буурахад нөлөөлсөн байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 65.7 хувь нь эцсийн хэрэглээнд, 20.1 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, 14.2 хувь нь цэвэр экспортод ногдож байна.

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн нэгдүгээр улиралд ДНБ-ий хэмжээ тухайн жилийн хамгийн бага утгыг үзүүлдэг бол хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2016-2020 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдийг 5 жилийн дунджаар авч үзвэл эцсийн хэрэглээ ДНБ-ий 64.6 хувийг, хөрөнгийн нийт хуримтлал 35.8 хувийг, цэвэр экспорт -0.4 хувийг эзэлсэн байна.

График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 0.3 их наяд төгрөг буюу 0.9 хувиар буурсан байна.

Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 0.3 их наяд төгрөг буюу 0.9 хувиар, зэрэгцүүлэх үнээр 18.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 1.0 их наяд төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Үүнд **аж үйлдвэр 0.4 их наяд, үйлчилгээ 0.6 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.2 их наяд төгрөгөөр тус тус буурсан** нь нөлөөлжээ.

График 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон 2020 оны ДНБ-ийг өссөн дүнгээр өмнөх онтой харьцуулахад хөдөө аж ахуй 0.4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн ч аж үйлдвэр 0.2 их наяд, үйлчилгээ болон худалдаа 0.1 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.5 их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр


Бүтэлдэхүүн	2016	2017	2018	2019	2020	Зөрүү
ДНБ	23,942.9	27,876.3	32,411.2	37,280.8	36,958.6	-322.3
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	2,798.8	2,865.4	3,495.7	4,026.6	4,458.8	432.3
Уул уурхай, олборлолт	4,817.3	6,543.4	7,721.0	8,642.6	7,994.0	-648.6
Боловсруулах үйлдвэрлэл	1,753.7	2,516.3	3,063.6	3,508.5	3,946.8	438.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	592.1	602.9	682.3	773.6	843.2	69.6
Барилга	949.1	1,029.8	1,191.1	1,411.0	1,360.6	-50.5
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	2,646.6	2,875.6	3,025.3	3,547.2	3,301.6	-245.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,239.4	1,370.4	1,516.7	1,732.6	1,392.2	-340.4
Мэдээлэл, холбоо	489.3	489.8	553.5	648.5	674.7	26.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6,665.9	7,042.7	7,643.5	8,977.5	9,430.8	453.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1,990.7	2,540.0	3,518.5	4,012.6	3,555.9	-456.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 37.0 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 40.0 хувийг үйлчилгээ, 38.3 хувийг аж үйлдвэр, 12.1 хувийг хөдөө аж ахуй, үлдэх 9.6 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлсэн байна.

График 5. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ийг оны үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбар 1.3 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 0.7 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 11.4 хувиар тус тус буурсан бол хөдөө аж ахуйн салбар 10.7 хувиар өссөн байна.




1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,459.5 мянган төгрөг байна.

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөг байж энэ үеэс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагатай байсан ба 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ний өсөлт 5.2 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,680.6 мянган төгрөг буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ буурч 2019 оны мөн үеэс 1.9 хувь буюу 221.1 мянган төгрөгөөр буурч 11,459.5 мянган төгрөгт хүрсэн байна.

График 6. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтээ хүрсэн байна. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны эхний улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай тооцоологдсон нь 2016 оноос хойш хамгийн доод хэмжээндээ хүрчээ. 2020 оны эхний хагас жилд -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрч эдийн засаг эргэн сэргэх хандлага ажиглагдаж байна.

График 7. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 2016-2020 оны төлвийг авч үзвэл 2016-2018 оны байдлаар 1.2-7.2 хувь хүртэл тогтмол өсч байсан бол 2019 оны хоёрдугаар улирлаас эхлэн буурчээ. 2019 оны жилийн эцсийн өсөлтийн хувийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.0 пунктээр буурч 5.2 хувьд хүрсэн бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа. Үүнд салбаруудын оролцоог авч үзвэл; хөдөө аж ахуйн салбар 6.2 хувийн өсөлт үзүүлснээс бусад салбаруудын үзүүлэлт тодорхой хувиар буурснаас хамаарч нийт эдийн засаг агшихад нөлөөлсөн байна. **ДНБ 5.3 хувийн бууралттай байгаа нь бүтээгдэхүүний цэвэр татвар 9.8 хувиар, уул уурхай, олборлолтын салбар 9.4 хувиар, үйлчилгээ 7.1 хувиар, аж үйлдвэрийн салбар 1.1 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс буурсантай холбоотой байна.**

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь өмнөх оноос 3,782.9 тэрбум төгрөгөөр буюу 5 дахин өссөн байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,421.6 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 13,960.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 636.4 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар дутуу биелсэн бол төсвийн нийт зарлага 1,145.4 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагджээ.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсөв

Үзүүлэлт	2020.12		Өөрчлөлт	
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	10,058.1	9,421.6	-636.4	-6.3
Нийт зарлагын дүн	15,106.1	13,960.8	-1,145.4	-7.6
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-5,048.1	-4,539.1	509.0	10.1
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-13.0	-12.3		

/тэрбум төгрөг/ Эх сурвалж: Сангийн яам

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,421.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 1,483.9 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар буурч, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 13,960.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2,299.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2017-2020 оны байдлаар

Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар				Өөрчлөлт(+/-)	
	2017	2018	2019	2020	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,274.9	9,225.9	10,905.5	9,421.6	-1,483.9	-13.6
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,017.3	9,222.9	11,661.7	13,960.8	2,299.1	19.7
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1,742.5	3.0	-756.2	-4,539.1	-3,782.9	500.2
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-6.4	0.1	-2.0	-12.3		

/тэрбум төгрөг/ Эх сурвалж: Сангийн яам

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь өмнөх оноос 3,782.9 тэрбум төгрөгөөр буюу 5 дахин өссөн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 12.3 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 10.3 пунктээр өссөн бол төлөвлөсөн дүнгээс 509.0 тэрбум төгрөгөөр буурч сайжирсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага хэмнэгдэж зарцуулагдсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурахад нөлөөлжээ.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,421.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 13.6 хувь буюу 1,483.9 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 6.3 хувь буюу 636.4 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.2 хувийг татварын орлого, 9.8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 9.1 хувь буюу 677.8 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 10.3 хувь буюу 52.4 тэрбум, Орон нутгийн төсөв 7.7 хувь буюу 268.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу

төвлөрсөн бол Нийгмийн даатгалын сангийн төсөв 5.0 хувь буюу 90.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 14.8 хувь буюу 1,178.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 23.4 хувь буюу 582.4 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 3.3 хувь буюу 15.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол орон нутгийн төсвийн орлого 9.1 хувь буюу 267.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлогын 2020 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар

/тэрбум төгрөг/


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,474.9	7,779.1	3,483.1	3,214.7	1,812.3	1,902.7	506.5	454.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	943.2	914.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	55.2	66.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,476.5	6,798.8	3,483.1	3,214.7	1,812.3	1,902.7	506.5	454.1
Татварын орлого	6,095.8	5,686.4	1,463.2	1,227.4	1,411.7	1,502.1	506.5	454.1
Орлогын албан татвар	1,736.4	1,398.5	1,003.9	822.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,411.7	1,502.1	506.5	454.1
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	175.1	154.5	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,278.0	2,205.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	734.9	776.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	16.0	17.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	771.0	740.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	559.6	548.0	284.2	250.9	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,380.7	1,112.4	2,019.9	1,987.4	400.5	400.5	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	602.8	583.9	219.9	195.8	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	1.5	1.1	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	418.9	353.1	8.7	7.2	400.5	400.5	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	358.9	175.3	1,789.8	1,783.2	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 8,501.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 6.4 хувь буюу 581.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрчээ.

Татварын орлогын 26.1 хувийг орлогын албан татвар, 18.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 25.9 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.1 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.4 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 8. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

2020 онд татварын орлого 581.8 сая төгрөгөөр тасалдахад орлогын албан татварын биелэлтийн дутуу гүйцэтгэл голлон нөлөөлсөн байна.

Төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын албан татвар 19.0 хувь /519.8 тэрбум төгрөг/, хөрөнгийн албан татвар 11.8 хувь /20.6 тэрбум төгрөг/, гадаад үйл ажиллагааны орлого 3.9 хувь /30.2 тэрбум төгрөг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.2 хувь /72.7 тэрбум төгрөг/, бусад татвар, төлбөр хураамж 5.3 хувь /44.9 тэрбум төгрөг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй гарсан бол тусгай зориулалтын орлого 7.0 хувь /1.1 тэрбум төгрөг/, онцгой албан татвар 5.7 хувь /42.0 тэрбум төгрөг/, нийгмийн даатгалын орлого 4.2 хувь /63.5 тэрбум төгрөг/-иар тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.


Өнгөрсөн онтой харьцуулахад 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 1,311.4 тэрбум төгрөг буюу 13.4 хувиар буурахад хөрөнгийн албан татвар 0.1 тэрбум (0.1%), тусгай зориулалтын орлого 0.7 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өссөн ч, орлогын албан татвар 335.8 тэрбум (13.1%), нийгмийн даатгалын орлого 442.5 тэрбум (21.8%), нэмэгдсэн өртгийн албан татвар 281.0 тэрбум (11.3%), онцгой албан татвар 86.5 тэрбум (10.0%), гадаад үйл ажиллагааны орлого 49.4 тэрбум (6.3%), бусад татвар, төлбөр, хураамж 117.0 тэрбум (12.8%) төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Татварын бус орлого 919.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 15.8 хувь буюу 172.5 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 54.7 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.4 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 11.3 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлого 43.0 тэрбум төгрөгөөр; түүн дотроо төсөвт байгууллагын өөрийн орлого 65.7 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 18.8 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 7.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хүүгийн орлого 11.6 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 4.1 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.8 тэрбум төгрөгөөр, бусад орлого 32.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

Татварын бус орлогын 84.8 хувийг нийтлэг татварын бус орлого, 15.1 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 38.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 13.2 хувийг газрын тосны орлого, 10.6 хувийг хүүгийн орлого, 9.6 хувийг навигацыйн орлого, 9.5 хувийг торгуулийн орлого, 2.7 хувийг хувьцааны ногдол ашиг, 0.7 хувийг түрээсийн орлого, 14.7 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.

График 9. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 15,106.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 92.4 хувийг ашиглаж 1,145.4 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,299.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 793.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 510.4 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 44.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 68.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,564.4 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 246.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 387.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 75.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөө биелэлт, %		Өөрчлөлт	
	2020.12	2019.12	2020.12	Төл./Гүйц.	Зөрүү	Хувь		
	1	2	3	(3:1)	(2-3)	(2-3)/2		
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,106.1	11,661.7	13,960.8	92.4	-2,299.1	-19.7		
НИЙТ ЗАРЛАГА	15,051.7	11,245.3	13,923.2	92.5	-2,677.9	-23.8		
УРСГАЛ ЗАРДАЛ	11,544.6	8,228.6	10,871.6	94.2	-2,643.0	-32.1		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,237.6	4,000.5	4,875.5	93.1	-875.0	-21.8		
ХҮҮ	979.0	861.0	959.4	98.0	-98.4	-11.4		
ТАТААС	455.5	298.9	374.2	82.1	-75.3	-25.2		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,872.6	3,068.2	4,662.5	95.7	-1,594.3	-52.0		
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,507.1	3,016.7	3,051.7	87.0	-35.0	-1.2		
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54.4	416.4	37.6	69.0	378.8	91.0		

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 19.7 хувь буюу 2,299.1 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 378.9 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 2,643.0 тэрбум, хөрөнгийн зардал 35.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 98.4 тэрбум төгрөг буюу 11.4 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 19.6 тэрбум төгрөг буюу 2.0 хувиар тус тус буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 10,871.6 тэрбум төгрөг буюу 77.9 хувь нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 44.8 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 42.9 хувийг урсгал шилжүүлэг, 8.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.4 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 2,643.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 875.0 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 98.4 тэрбум, татаас 75.3 тэрбум, урсгал шилжүүлэг 1,594.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл:

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 12.3 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 6. Төсвийн тэнцэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн эцсийн байдлаар			Төл.	Гүйц.	Өөрчлөлт(+/-)	
						2020.12/2019.12	
	2017	2018	2019	2020		дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1,742.5	3.0	-756.2	-5,048.1	-4,539.1	-3,782.9	-
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-6.4	0.1	-2.0	-13.0	-12.3	-10.3	-

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4,060.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 546.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан бол орон нутгийн төсөв 40.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 27.8 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 691.1 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 263.0 тэрбум төгрөг төлж, 1,380.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн болон 1,978.1 тэрбум төгрөгийн гадаад хөтөлбөрийн зээл шинээр авч, мөн 25.7 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна. 1,712.7 тэрбум төгрөгийн засгийн газрын урт хугацаат гадаад бонд шинээр гаргасан байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт:

2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өнгөрсөн оны мөн үеэс 6.4 хувь буюу 876.9 сая ам.доллараар буурч 12,870.3 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улс дэлхийн 146 улстай гадаад худалдаа хийсэн байна. Экспорт 43.5 сая ам.доллар буюу 0.6 хувиар, импорт 833.5 сая ам.доллар буюу 13.6 хувиар тус тус буурсан байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн дөрвөн жил дараалан ашигтай гарсан байна.

Хүснэгт 7. Гадаад худалдааны үзүүлэлт

Үзүүлэлт	12 дугаар сар				Өөрчлөлт	
	2017	2018	2019	2020	Зөрүү	Хувь
Нийт эргэлт	10,537.9	12,886.8	13,747.2	12,870.3	-876.9	-6.4
-Экспорт	6,200.6	7,011.8	7,619.8	7,576.3	-43.5	-0.6
-Импорт	4,337.3	5,875.0	6,127.4	5,293.9	-833.5	-13.6
Тэнцэл	1,863.3	1,136.7	1,492.3	2,282.4	790.1	52.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2020 оны жилийн эцсийн байдлаар гадаад худалдааны тэнцэл 2,282.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 790.1 сая ам.доллар буюу 52.9 хувиар өсөхөд импортын бууралт 833.5 сая ам.доллар болж экспортын бууралтаас 19.2 дахин их байгаа нь нөлөөлсөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2020 оны гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 880.7 сая ам.доллараар өсөж 2,515.7 сая ам долларын ашигтай гарсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл нийт бараа эргэлтийн 57.5% буюу 7,403.8 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 11.3% буюу 1,457.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 18.9%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 16.3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

Улс	Төрөл	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2018	2019	2020	2020.12/2019.12	
						Зөрүү	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	57.5	8,537.6	8,850.5	7,403.8	-1,446.7	-16.3
	Экспорт	72.5	6,542.8	6,789.7	5,493.6	-1,296.1	-19.1
	Импорт	36.1	1,994.8	2,060.8	1,910.2	-150.6	-7.3
	Тэнцэл		4,548.0	4,728.9	3,583.4	-1,145.5	-24.2
ОХУ	Нийт эргэлт	11.3	1,796.2	1,798.0	1,457.3	-340.7	-18.9
	Экспорт	0.8	85.9	68.1	57.3	-10.8	-15.9
	Импорт	26.4	1,710.3	1,729.9	1,400.0	-329.9	-19.1
	Тэнцэл		-1,624.4	-1,661.8	-1,342.7	319.1	-19.2
Бусад	Нийт эргэлт	31.2	2,552.8	3,098.6	4,009.1	910.5	29.4
	Экспорт	26.7	383.1	761.8	2,025.4	1,263.6	165.9
	Импорт	37.5	2,169.7	2,336.8	1,983.7	-353.1	-15.1
	Тэнцэл		-1,786.6	-1,575.0	41.7	1,616.7	102.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаг үеийн онцгой байдлаас шалтгаалж БНХАУ-тай хийх экспортын худалдаа 19.1 хувь буюу 1,296.1 сая ам.доллараар, ОХУ-тай хийсэн экспортын худалдаа 15.9 хувь буюу 10.8 сая ам.доллараар буурсан. Харин бусад орнуудтай хийсэн экспортын худалдаа 1,263.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

ОХУ-тай хийсэн импортын худалдаа 329.9 сая ам.доллар буюу 19.1 хувиар, БНХАУ-тай хийсэн импортын худалдаа 150.6 сая ам.доллар буюу 7.3 хувиар, бусад орнуудтай хийсэн импортын худалдаа 353.1 сая ам.доллар буюу 15.1 хувиар тус тус буурсан байна.

Монгол Улсын гадаад худалдаа ОХУ-тай алдагдалдтай, БНХАУ болон бусад орнуудтай ашигтай гарсан бөгөөд нийт худалдааны ашиг 2019 онтой харьцуулахад 53.0 хувиар нэмэгдсэн байна.

3.2. Экспорт:

Экспортын худалдаа 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 7,576.3 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 43.5 сая ам.доллар буюу 0.6 хувиар нэмэгдсэн байна. Үүнд эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт 1,078.2 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2020 онд 69.4 хувьд хүрч, өнгөрсөн оноос 14.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 9. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцэс				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	4,933.7	6,070.3	6,377.5	5,255.8	-1,121.7	-17.6	69.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,266.9	941.5	1,242.3	2,320.5	1,078.2	86.8	30.6
Нийт экспорт	6,200.6	7,011.8	7,619.8	7,576.3	-43.5	-0.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспортын орлогын 8-аас багагүй хувийг эзэлдэг бүтээгдэхүүнд зэсийн баяжмал, нүүрс болон төмрийн хүдэр, алт багтаж байна.

График 10. Нүүрс, зэсийн баяжмал болон алтны экспорт /тэрбум ам.дол/





График 11. Төмөр, газрын тос болон цайрын баяжмалын экспорт /тэрбум ам.дол/



Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 5,255.8 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1,121.7 сая ам.доллар буюу 17.6 хувиар буурсан бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 2,320.5 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1,078.2 сая ам.доллар буюу 86.8 хувиар өссөн байна. Нийт экспортын 69.4 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 30.6 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Хүснэгт 10. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт

№	Төрөл	Хэмжих нэр	2015.12	2016.12	2017.12	2018.12	2019.12	2020.12
1	Зэсийн баяжмал	мян.тн	1,477.8	1,562.0	1,447.2	1,436.7	1,403.2	1,395.1
		сая ам.дол	2,280.1	1,607.8	1,613.1	2,012.2	1,795.9	1,778.0
2	Нүүрс	сая.тн	14.5	25.8	33.4	36.3	36.6	28.7
		сая ам.дол	555.9	973.1	2,267.6	2,802.5	3,078.8	2,126.6
3	Төмрийн хүдэр	сая.тн	5.1	6.1	6.3	7.4	8.4	8.2
		сая ам.дол	227.2	249.9	313.4	342.2	576.6	639.7
4	Түүхий газрын тос	сая.баррел	8.1	8.0	7.5	6.2	6.5	4.1
		сая ам.дол	387.2	337.2	374.1	392.0	366.7	150.9
5	Алт	тн	11.3	19.2	14.6	3.4	9.1	30.5
		сая ам.дол	420.6	758.4	595.4	144.5	418.4	1,787.7
6	Цайрын баяжмал	мян.тн	84.1	126.0	118.2	123.9	134.8	134.1
		сая ам.дол	101.7	145.4	180.8	197.8	189.0	167.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Чулуун нүүрс: 2020 оны 12 сарын байдлаар 2,123.7 сая ам.долларын 28.6 сая тонн чулуун нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 950.7 сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд 7.9 сая тонноор тус тус буурсан байна. 2019 оны мөн үед 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ 84.3 ам.доллар байсан бол энэ онд 74.3 ам.доллар болж буурчээ. Чулуун нүүрсний 94.6 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмал: 2020 онд 1,395.1 мянган тонн зэсийн баяжмал экспортлосон нь өнгөрсөн онтой харьцуулбал 8.6 мянган тонноор бага байна. 2019 онд зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,279.5 ам.доллар байсан бол 2020 онд 1,274.5 болж 5.0 ам.доллараар буурсан бөгөөд үнийн дүнгээр 1,778.0 сая ам.доллар болж өмнөх оноос 17.9 сая ам.доллараар буурчээ.

Цайрын баяжмал: 2020 онд 134.1 мянган тонн цайрын баяжмалын 1 тонныг дунджаар 1,250.7 ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспортын дундаж үнэ 151.6 ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр 167.7 сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос 21.3 сая ам.доллараар буурчээ.

3.3. Импорт:

2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр импортын хэмжээ 5,293.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 833.6 сая ам.доллар буюу 13.6 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,007.2 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 365.1 сая ам.доллар буюу 26.6 хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 4,286.7 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 468.5 сая ам.доллар буюу 9.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт импортын 19.0 хувийг нь эрдсийн бүтээгдэхүүний импорт, 81.0 хувийг нь эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцэс				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2017	2018	2019	2020	Зөрүү	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	985.9	1,325.8	1,372.3	1,007.2	-365.1	-26.6	19.0
Эрдсээс бусад бүтээгдэхүүн импорт	3,351.4	4,549.0	4,755.2	4,286.7	-468.5	-9.9	81.0
Нийт импорт	4,337.3	5,874.8	6,127.5	5,293.9	-833.6	-13.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 376 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 349 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 30 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 88 сая ам.доллараар буурснаар нийт импорт 833.6 сая ам.доллараар буурлаа.

Хүснэгт 13. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	Жилийн эцсийн гүйцэтгэл						Өөрчлөлт Сая ам.дол
	2018		2019		2020		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	2020/2019
Хэрэглээ	1,643	28%	1,631	27%	1,542	29%	-88
-Түргэн эдэлгээтэй	864	15%	859	14%	878	17%	19
-Удаан эдэлгээтэй	779	13%	772	13%	664	13%	-108
Хөрөнгө оруулалт	2,396	41%	2,661	43%	2,285	43%	-376
-Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	1,512	26%	1,801	29%	1,414	27%	-387
-Барилгын материал	648	11%	654	11%	599	11%	-54
-Хөрөнгө оруулалтын бусад бараа	236	4%	206	3%	272	5%	65
Аж үйлдвэрлэлийн орц	717	12%	665	11%	634	12%	-30
-Цахилгаан эрчим хүч	143	2%	144	2%	142	3%	-2
Нефтийн бүтээгдэхүүн	1,112	19%	1,166	19%	817	15%	-349
-Дизель	577	10%	669	11%	432	8%	-237
-АИ-92, 95	264	4%	289	5%	222	4%	-68
-А80 ба бусад	272	5%	207	3%	163	3%	-44

Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оноос 88 сая ам.доллараар буурахад автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 123 сая ам.доллараар болон гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ба тавилгын импорт 3 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 376 сая ам.доллараар буурахад суудлаас бусад машин, механизм, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийн импорт 156 сая ам.доллар, машин механик, тоног төхөөрөмж, эд ангийн импорт 231 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оноос 349 сая ам.доллараар буурсан байна. Дизель түлшний импорт 237 сая ам.доллар, бензин 112 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ.

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 24,220.0 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3,386.4 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 3,093.1 тэрбум төгрөгөөр буюу 18.3 хувиар өссөн нь нөлөөлжээ. Төгрөгийн хадгаламж 2,278.7 тэрбум төгрөг буюу 20.5 хувь, валютын хадгаламж 1,158.0 тэрбум төгрөг буюу 33.2 хувиар тус тус өссөн бол валютын харилцах 343.6 тэрбум төгрөгөөр буюу 14.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 13. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2020.12/2019.12	
	2017	2018	2019	2020	Зөрүү	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	15,861.2	19,474.7	20,833.6	24,220.0	3,386.4	16.3%
Бараг мөнгө	13,035.2	15,443.7	16,929.5	20,022.6	3,093.1	18.3%
-Төгрөгийн хадгаламж	8,622.0	10,156.2	11,119.6	13,398.3	2,278.7	20.5%
-Валютын хадгаламж	2,531.9	3,019.5	3,483.7	4,641.7	1,158.0	33.2%
-Валютын харилцах	1,881.3	2,268.0	2,326.2	1,982.6	-343.6	-14.8%
M1 мөнгө	2,826.0	4,031.0	3,904.1	4,197.4	293.3	7.5%
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	906.4	968.6	897.4	991.5	94.1	10.5%

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 17.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 0.9 их наяд төгрөг буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 14. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2020.12/2019.12	
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	13,615.1	17,225.7	18,096.1	17,206.9	-889.2	-4.9%
-Хэвийн зээл	11,638.8	14,592.4	15,447.0	13,928.0	-1,519.0	-9.8%
-Хугацаа хэтэрсэн зээл	823.3	848.8	824.0	1,269.4	445.3	54.0%
-Чанаргүй зээл	1,153.0	1,784.5	1,825.1	2,009.6	184.4	10.1%
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	8.5	10.4	10.1	11.7	1.6	15.8%
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	6.0	4.9	4.6	7.4	2.8	62.0%

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцэст 1,269.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 445.3 тэрбум төгрөг буюу 54.0 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувь, хэвийн зээлийн 9.1 хувийг тус тус эзэлжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны жилийн эцэст 2,009.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 184.4 тэрбум төгрөг буюу 10.1 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувь, хэвийн зээлийн 14.4 хувийг эзэлсэн байна. Нийт чанаргүй зээлийн 74.3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээл, 25.1 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээл 10.1 хувиар өсөхөд иргэдийн зээл 50.8 хувь буюу 170.0 тэрбум төгрөгөөр өссөн нь гол нөлөөллийг үзүүлсэн байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2020 оны жилийн эцэст нийт 353.3 сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, 53.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 66.6 хувиар буурсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2020 оны жилийн эцсийн байдлаар 0.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 97.9 хувиар буюу 27.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2020 оны жилийн эцэст 18,126.1 болж, өмнөх оны мөн үеэс 828.8 нэгж буюу 4.4 хувиар буурчээ.

Валютын ханш: 2020 оны жилийн эцэст Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,849.55 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.02 хувиар чангарсан бол оны эхнээс 3.8 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 435.64 төгрөг болж өмнөх сараас 1.0 хувиар, оны эхнээс 9.9 хувиар суларсан байна.


График 12. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юаны дундаж ханш, төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны жилийн эцэст 2.3 хувь болж өмнөх сараас 1.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан байна.

График 13. Инфляцын түвшин, хувиар




Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 4,534.2 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 185.6 сая ам.доллар буюу 4.3 хувиар нэмэгдсэн байна. Коронавирусийн цар тахлын дэгдэлтээс үүдэж 2020 оны эхний хагаст экспорт хурдацтай буурч, Засгийн газрын баталгаатай аж ахуйн нэгжийн бондын төлбөр гадагшаа хийгдэж, урсгал дансны алдагдал өссөн хэдий ч сүүлийн хагасаас гадаад орчинд эерэг өөрчлөлт гарснаар богино хугацаат гадаад өр төлбөрийг хойшлуулж, доноруудын том дүнтэй санхүүжилт орж ирэн, Монголбанкинд тушаах алтны хэмжээ нэмэгдэж, нүүрсний экспортын хэмжээ өссөн зэрэг нь нөлөөлжээ.

График 14. Нийт албан нөөц, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2020 оны жилийн эцсийн байдлаар 4,534.2 сая ам.доллар буюу сүүлийн 12 сарын дунджаар тооцсон импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ 13.6 хувиар буурсан бол нөгөө талд гадаад валютын албан нөөц 4.3 хувиар нэмэгдсэн нь импортын сарын хэрэгцээг хангах түвшинг нэмэгдүүлжээ.

Хүснэгт 15. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	2015.12	2016.12	2017.12	2018.12	2019.12	2020.12
1	Нийт импорт	3,797.5	3,358.1	4,337.3	5,875.0	6,127.4	5,293.9
2	Гадаад валютын нийт нөөц	1,323.1	1,296.3	3,008.1	3,549.1	4,348.6	4,534.2
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	5.0	4.9	8.0	7.6	9.1	10.7

Эх сурвалж: Монголбанк, Үндсэний статистикийн хороо

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 23.6 тонн болж, өмнөх оны мөн үеэс 8.4 тонноор өссөн байна. Дэлхийн зах зээл дээр алтны үнэ оны эхнээс 21 хувиар өссөн, томоохон алтны үндсэн орд ашиглалтад орж олборлолтын хэмжээ нэмэгдсэн, хууль бусаар алт хилээр нэвтрүүлэх нь буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлөв. Түүнчлэн Монголбанкнаас “Алт-2” хөтөлбөрийг эрчимжүүлснээр алтны салбарын экспортын хэмжээ 2020 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оноос 4.3 дахин өсч 1,8 тэрбум ам.долларт хүрсэн. Мөн өнгөрсөн жилүүдэд Дархан-Уул, Баянхонгор аймагт үнэт металл худалдан авдаг болж, үнэт металлын арилжаа эрхлэгч иргэдэд тусгай зөвшөөрөл олгох, үнэт металлын сорьцын шинжилгээний үр дүн болон төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүдийг цахимжуулсан гэх мэт үр дүнд Монголбанкинд худалдах үнэт металлын хэмжээ ийнхүү өссөн гэж Монголбанк үзсэн байна.

График 15. Монголбанкны худалдан авсан алт, кг



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 576.2 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 1,494.3 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 786.9 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 334.0 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцлийн алдагдал 576.2 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 456.3 сая ам.доллар, бараа ба үйлчилгээ 281.3 сая ам.доллар гарсан бол харин цэвэр орлого 1,313.8 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 1,585.5 сая ам.доллараар буурч сайжирсан байна. Урсгал тэнцлийн алдагдал буурахад бараа ба үйлчилгээний худалдаа 1,114.9 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

2020 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 1,494.3 сая ам.долларын илүүдэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 1,344.1 сая ам.доллараар буурсан байна. Төлбөрийн тэнцэл 786.9 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 334.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 16. Төлбөрийн тэнцэл, 2018.12 - 2020.12

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Гүйцэтгэл			Жилийн эцсийн өөрчлөлт (+/-)	
	2018.I-XII	2019.I-XII	2020.I-XII	2019/2018	2020/2019
I. Урсгал Тэнцэл	-2,206.8	-2,161.7	-576.2	45.1	1,585.5
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-1,302.8	-833.6	281.3	469.2	1,114.9
В. Орлого	-1,227.5	-1,568.8	-1,313.8	-341.3	255.0
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	323.5	240.7	456.3	-82.8	215.6
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	2,182.9	2,838.5	1,494.3	655.6	-1,344.1
А. Хөрөнгийн данс	91.9	160.8	105.8	68.9	-55.0
В. Санхүүгийн данс	2,091.0	2,677.6	1,388.6	586.6	-1,289.1
III. Алдаа болон орхигдуулга	-117.8	-223.9	-131.2	-106.1	92.7
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-141.7	452.9	786.9	594.6	334.0

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


5.1. Хүн ам, ажил эрхлэлт:

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын хүн ам 3.4 сая болж өнгөрсөн оноос 62.0 мянган хүнээр өссөн байна. Улсын хэмжээнд 2020 онд 77.9 мянган хүүхэд шинээр төрж, төрсөн хүүхэд өмнөх оноос 2.9 хувиар буурчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн 30.0 мянган хүнээс 18.1 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.9 мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 12.8 хувь буюу 2.7 мянгаар буурсан байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.7 хувь нь бүрэн дунд, 26.2 хувь нь дипломын дээд болон бакалаврын, 10.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.3 хувь нь суурь, 2.2 хувь нь бага, 0.9 хувь нь магистр, доктор, 1.4 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.9 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

График 16. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 17. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,216.6 мянга болж, өмнөх оноос 76.9 мянга (5.9%) -аар буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 57.0 хувь болж өнгөрсөн оноос 3.7 пунктээр буурсан байна. Тус түвшинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийнх 65.1 хувь, эмэгтэйчүүдийнх 50.0 хувь байна.

Харин 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 918.1 мянга болж, өмнөх оноос 79.5 мянган иргэдээр өссөн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 66.1 (7.2%) мянга нь боломжит ажиллах хүч (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан эсвэл тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна.

5.2. Ажилгүйдэл:

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 7.6 хувьтай болж, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 пунктээр буурч, өмнөх улирлаас 0.3 пунктээр өссөн байна

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 7.6 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.3 хувь, эмэгтэйчүүдийнх 7.9 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 8.6 хувь буюу улсын дунджаас 1.0 пунктээр дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.0 хувь байгаа нь улсын дунджаас 2.6 пунктээр доогуур байна. Ажилгүйдлийн түвшнийг бүсээр харахад, Зүүн бүсэд 10.8 хувь байгаа нь улсын дунджаас 3.2 пунктээр дээгүүр байна. Ажилгүйдлийн түвшнийг аймгаар авч үзэхэд Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Говьсүмбэр, Дархан-Уул, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Баян-Өлгий аймагт улсын дунджаас 0.1-13.0 пунктээр дээгүүр байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

